

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТАЙЛАН

ИТХурлын хуралдаанаар:

ИТХурлын Төлөөлөгчдийн XII хуралдаан 2019 оны 02 дугаар сарын 27 нд хуралдаж, хуралдаан 61 хувийн ирцтэй хуралдаж, тус хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцлээ.

1.Сумын ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын журам батлах тухай 2018 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 08/02 тогтоолыг хүчингүй болгох тухай

2. 2020 оны малын халдварт өвчнөөс сэргийлэх био бэлдмэлийн захиалга хэлэлцэх

3. 2018 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцэх

4. Багийн хилийн зааг тодорхойлох, хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх ажлын хэсэг байгуулах

5.Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн ажлын төлөвлөгөө батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэв.

Баталсан шийдвэрүүд:

1.Тогтоол хүчингүй болгох тухай

ИТХ-ын2018 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн “Журам батлах тухай” /сумын ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын журам/08/02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов.

2. Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн ажлын төлөвлөгөө батлах тухай

”Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө батлав.

”Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жилээр танилцуулахыг сумын Засаг дарга Х.Дашдэлэг-д үүрэг болгов.

3. Багуудын хилийн заагийг тодорхойлох тухай

Багуудын нутаг дэвсгэрийн нийт талбайн хэмжээг нэгдүгээр, Туяа багийн хилийн заагийн эргэлтийн цэгийг хоёрдугаар, Арвайнтал багийн хилийн заагийн эргэлтийн цэгийг гуравдугаар, Хүрэмт багийн хилийн заагийн эргэлтийн цэгийг дөрөвдүгээр, Урт багийн хилийн заагийн эргэлтийн цэгийг тавдугаар, Ихбулаг багийн хилийн заагийн эргэлтийн цэгийг зургаадугаар, Алтан тал багийн хилийн заагийн эргэлтийн цэгийг долоодугаар хавсралтаар батлав.

4. Ажлын хэсэг байгуулах тухай

1.Сумын нутаг дэвсгэртэй хил залгаа оршдог Хайрхандулаан, Уянга, Зүүнбаян-Улаан сумдын хилийн цэсийн маргааныг газар дээр нь мэргэжлийн хүмүүстэй шийдвэрлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулав.

Ажлын хэсгийн ахлагч Газрын даамал Э.Оюун-Эрдэнэ

Гишүүдэд-1-р багийн багийн Засаг дарга Т.Бямбасүрэн, Д.Адилбиш малчин

2-р баг багийн Засаг дарга П.Давгадорж, Уртнасан малчин

3-р баг багийн Засаг дарга Д.Баасандорж Ш.Чимэддорж төлөөлөгч

4-р баг багийн Засаг дарга багийн ИНХурлын дарга Лхавгадорж

5-р багийн Засаг дарга Ю.Бор малчин

6-р багийн Засаг дарга С.Чинзориг

ИТХурлын Тэргүүлэгчдийн хуралдаан:

ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1-р улиралд 4 удаа хуралдаж, хуралдааны ирц 84 хувьтай, **13 асуудал хэлэлцэж, 14 шийдвэр батлан** хэрэгжүүлж байна.

Хэлэлцсэн асуудал:

1. 2018 онд төсөвт албан байгууллагуудад орон нутгийн хөгжлийн сан болон хандив, тусламж, төсөл хөтөлбөрөөр хийгдсэн хөрөнгө оруулалтуудыг хөрөнгөнд бүртгэх тухай
2. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
3. 2018 оны сумын сайн малчдыг шалгаруулах тухай
4. ИТХ-ын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай
5. Хөгжих өрхүүдийг баталгаажуулах тухай
6. ГХУСЗАСЗөвлөлийн 2019 оны жилийн ажлын төлөвлөгөө
7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоход санал, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус салбар зөвлөл байгуулах тухай
8. Сумын ИТХурлын даргын цалин тогтоох тухай
9. ИТХурлын XII хуралдаан зарлах тухай
10. Алдарт эх"-ийн хоёрдугаар зэргийн одонд уламжлах эхчүүдийн материал хэлэлцэх тухай,
11. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын комиссын бүрэлдэхүүнийг байгуулах тухай
12. ЕБСургуулийн хуучин дотуур байрыг ЕБСургуулийн баланснаас ЗДТГазарт балансад шилжүүлж өгөх ЕБСургуулийн албан тоот хэлэлцэх
13. ЕБСургуулийн үйл ажиллагаатай холбоотой асуудал хэлэлцэх

Баталсан шийдвэрүүд:

1. Хөрөнгө бүртгэх тухай:

Төсөвт албан байгууллагуудад орон нутгийн хөгжлийн сан болон хандив, тусламж, төсөл хөтөлбөрөөр хийгдсэн 105 нэр төрөлийн 226,517,906 төгрөгийн хөрөнгийг хөрөнгөнд бүртгэв.

№	Хөрөнгө оруулалт, хандив өгсөн ААНБ, иргэний нэр	Хөрөнгө оруулалт авсан байгууллага	Хөрөнгө оруулалтын нэр	Тоо ширхэг	Мөнгөн дүн		
1	Улсын төсөв	ИТХурал	Проектор	1	1,000,000		
2	Нийт				1,000,000		
3	ОНХСан	ЗДТГазар	20 ковш	1	22,288,000		
4			Фургон	1	35,000,000		
5			Өнгөт принтер	1	420,000		
6			3 үйлдэлт принтер	1	280,000		
7			Чиглэл заагч	1	400,000		
8			Суурийн компьютер	2	900,000		
9			Их булаг багийн төвийн барилга	1	50,000,000		
10			Малын тарилгын хашаа	1	2,000,000		
11			ХХААГазар		МЭҮТасаг мотоцикль	1	2,921,820
12					Зөөврийн мал угаалгын тоног төхөөрөмж	1	11,836,133
13	Утагч	3			960,000		

14	Улсын төсөв		Үлий цөмлөгч	3	1,290,000		
15			Мотор	1	550,000		
16			Помп	1	352,000		
17			1 тн усны сав	1	330,000		
18			Компьютер	2	1,960,000		
19			Дрилл	2	143,000		
20			ДЗОУБ		Модон шүүгээ	1	363,096
21	Сандал	1			122,400		
22	Нийт				132,116,449		
23	Улсын төсөв	ЕБСургууль	Хичээлийн байрны их засвар	1	30,000,000		
24			Багш хөгжлийн өрөөний тохижилт	1	2,964,200		
25			Зөөврийн компьютер	1	2,310,000		
26			Өнгөт принтер	1	1,050,000		
27			Өнэгөт зурагт	7	4,200,000		
28			Хурлын ширээ	1	950,000		
29			Буйдан	2	1,700,000		
30			Буйдан 3 хос	1	1,300,000		
31			Самбар	11	2,530,000		
32			Самбар	1	160,000		
33			Төмөр шкаб	2	700,000		
34			Сандал	30	1,050,000		
35			Хөшиг	3	355,800		
36			Гэрэл	6	210,000		
37			ДЗОУБ		Угаалгын машин	2	2,072,710
38					Угаалтуур	1	582,000
39					Ус буцалгагч	1	133,860
40			БСУГазар		Толь	4	200,000
41					Ширээ	5	560,000
42					Сандал	20	1,120,000
43					Ном	5	92,000
44			Хандив		Проектор дэлгэц	1	1,142,600
45					Лед гэрэл	4	300,000
46	Нийт				56,683,170		
47	Улсын төсөв		1-р хоолны тогоо	1	1,520,000		
48			2-р хоолны тогоо	1	2,000,000		
49			Аяга ариутгагч	1	520,000		
50			Буузны жигнүүр	1	780,000		
51			Бэлтгэлийн ширээ	1	300,000		
52			Ган савны иж бүрдэл	1 ком	290,000		
53			Гурил зуурагч	1	680,000		
54			Дээжний хөргөгч	1	390,000		
55			Ус буцалгагч	1	90,000		
56			хөлдөөгч	1	430,000		
57			Хөргөгч	1	760,000		
58			Цахилгаан пийшин	1	2,200,000		
59			Шарах шүүгээ	1	1,900,000		
60			Будаа агшаагч	1	70,000		
61			Махны машин	1	680,000		

62			Цахилгаан гурил хэрчигч	1	480,000
63			4 сандалтай ширээ	1	420,000
64			Биеийн тамир чийрэгжүүлэлтийн хэрэглэгдэхүүн	1	1,200,000
65		Цэцэрлэг	Сургалтын хэрэглэгдэхүүн	1	800,000
66			Өсгөгч /хос/	2	1,282,500
67			Хивс /4*5/	4	3,032,727
68			Шалны хулдаас	100	2,200,000
69	ДЗМОУБ		Микшир пульт	1	902,500
70			Утасгүй микрофон	2	475,000
71			Эгшигт хонх	2	84,200
72			Ширээний хонх	1	190,500
73			Бөмбөр	4	78,000
74			Кастанет	1	2500
75			Хос дуут мод	1	6550
76			Хавсардаг мод	1	3900
77			Төмөр царгил	1	112,800
78			Дэвсдэг кэйборд	2	343,520
79			Глокеншпиль	3	145,950
80	Хүрэмт хамтын хүч нөхөрлөл		Нидрүүлэг	1	9950
81			Цохивор хөгжмийн багц	1	70,200
82			Гурвалжин	1	5200
83			Туузан хонх	1	3740
84			Дуут мод	1	6550
85			Ком бөмбөр	1	220,000
86			Эвхдэг даралтат хөгжим	2	360,000
87			Пианика	3	60,000
88	Нийт				25,106,287
89		Соёлын төв	Яригч	2	2,460,000
90			Чадал	1	1,205,000
91	Улсын төсөв		Мишкер	1	840,000
92			Микрофон	2	190,000
93			Ном	94	1,500,000
94	Нийт				6,195,000
95		Туяа багийн ЕБС	Номын тавиур	5	1,249,500
96	БСШУСЯам		ширээ / SМЕМ/	2	224,000
97			сандал / STEM/	8	448,000
98			Ном	2	55,000
99	Нийт				727,000
100	ОНХСан		Эмчилгээний тоног төхөөрөмж		2,000,000
101		ЭМТөв	Утлагын аппарат		500,000
102	Улсын төсөв		Зөөврийн компьютер		950,000

10 3		Камержуулалт	880,000
10 4		Цаг бүртгэл машин	360,000
10 5	Нийт		4,690,000
10 6	Сумын нийт дүн		226,517,906

2. Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн нарийн бичгийн дарга Ш.Чулуунхүү өөр ажилд шилжсэнтэй холбогдуулан амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд Төмөрбаатар овогтой Нямдавааг бүрэлдэхүүнд батлав.

3. Хөгжих өрхүүдийг баталгаажуулах тухай

”Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай Арвайн тал багийн О.Баярхүү, Ж.Сумъяасүрэн, Хүрэмт багийн М.Лхавгасүрэн, Ж.Тогоосүрэн, Б.Мөнхтогтох, П.Лхагвасүрэн, Б.Мөнхбат, Т.Эрхэмбаяр, Ц.Батбилэг, Ч.Батхүү, Р.Адъяа, Б.Бат-Очир, Л.Мөнх-Эрдэнэ, А.Ганболд, Б.Энхболд, Д.Буянбаяр, О.Гансүх, Т.Отгонсүрэн, Н.Төртүвшин, Ихбулаг багийн Ч.Батболд нарын хорин өрхийг хөгжүүлэхээр баталгаажуулж, өрхүүдэд хөгжих өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, үр дүнг тооцон ИТХурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг Засаг дарга /Х.Дашдэлэг/-д үүрэг болгов.

4. Сумын сайн малчин шалгаруулах тухай

Мал аж ахуйн салбарт тууштай хөдөлмөрлөж, ажлын байр нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах талаар санаачилгатай ажиллаж бусдыгаа үлгэрлэн манлайлж байгаа ажлын амжилтуудыг өндрөөр үнэлж дараах нэр бүхий малчдыг “Сумын сайн малчин”-аар шалгаруулсугай.

1-р багийн малчин Аюуш овогтой Гантөмөр

2-р багийн малчин Уртнасан овогтой Пүрэвдаваа

3-р багийн малчин Мөнхжаргал овогтой Тогооч

3-р багийн малчин Жамбалдорж овогтой Гаваацоодол

4-р багийн малчин Одоохүү овогтой Гантөмөр

5-р багийн малчин Юндэн овогтой Бор

6-р багийн малчин Цоодол овогтой Цэрэн

2018 оны “сумын сайн малчин”-аар шалгарсан нэр бүхий малчдад “Сумын сайн малчин” энгэрийн тэмдэг, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулахыг Засаг дарга Х.Дашдэлэг-д даалгав.

5.Төлөвлөгөө батлах тухай

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлав.

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилт, үр дүнг тооцон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг ИТХТэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргалд үүрэг болгов.

6. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнтөмилөх тухай

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоход санал, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгомиллов.

Салбар зөвлөлийн дарга: Х.Дашдэлэг- Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Д.Баяржаргал- Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Б.Батцэцэг- Засаг даргын Тамгын газрын дарга

Ш.Элбэгжаргал- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Ө.Ишдорж- Хэсгийн төлөөлөгч

Д.Баасандорж- 3-р багийн Засаг дарга

Д.Оюунжаргал- Иргэний төлөөлөл

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн иргэн аж ахуй нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн баримт, материалыг хүлээн авч стандарт шаардлагыг хууль тогтоомжийн дагуу хангасан эсэхэд санал дүгнэлт гаргаж, холбогдох материалыг аймгийн зөвлөлд хүргүүлж ажиллахыг салбар зөвлөлд даалгав.

7. Цалин шинэчлэн тогтоох тухай

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Ламцэрэнгийн сарын үндсэн цалинг 840108 (найман зуун дөчин мянга нэг зуун найман мянга) төгрөгөөр тогтоов.

8.Төлөвлөгөө батлах тухай

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлав

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг удирдлага зохион байгуулалтаар ханган, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг ГХУСАЗЗөвлөлийн дарга Д.Ламцэрэнд үүрэг болгов.

9. ИТХурлын XII хуралдаан товлон зарлах тухай

Сумын ИТХурлын ээлжит XII-р хуралдааныг 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Лхавга гарагийн 9⁰⁰ цагт сумын төвд хуралдуулахаар зарлаж, дараах асуудлуудыг хэлэлцэхээр батлав.

1.1Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн ажлын төлөвлөгөө батлах

1.2 2020 оны малын халдварт өвчнөөс сэргийлэх био бэлдмэлийн захиалга хэлэлцэх

1.3 2018 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцэх

1.4 Багийн хилийн зааг тодорхойлох, хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх ажлын хэсэг байгуулах

ИТХ-ын ээлжит XII-р хуралдааны бэлтгэл ажлыг ханган ажиллахыг ИТХурлын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал, ЗДТГ-ын дарга Б.Батцэцэг нарт даалгасан.

10. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын комиссын бүрэлдэхүүнийг байгуулж, ажиллуулах тухай

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын ажлыг зохион байгуулж явуулах тооллогын комиссын бүрэлдэхүүнийг баталсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга: Х.Дашдэлэг-Засаг дарга

Тооллогын комиссын орлогч дарга: М.Төрболд-Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Б.Саруул-Санхүү албаны дарга

Гишүүдэд: Ш.Элбэгжаргал-ИТХурлын нарийн бичгийн дарга

Б.Батцэцэг-ЗДТГ-ын дарга

Д.Наранцэцэг-Иргэний бүртгэлийн ажилтан

Э.Есөн-Эрдэнэ -Төрийн захиргааны түшмэл

Д.Энхбаатар-Эрүүл мэндийн төвийн дарга
Ц.Хоролмаа- ЕБСургуулийн захирал
Э.Оюун-Эрдэнэ- Газрын даамал
Ж.Батзориг -БОХ-ын улсын байцаагч

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган, ажын явц байдалд хяналт тавьж, тооллогын дүн материалыг хүлээн авч нэгтгэх, аймгийн комисст хүлээлгэн өгөх ажлыг хугацаанд нь зохион байгуулахыг сумын түр комиссын дарга, Засаг дарга Х.Дашдэлэг-д үүрэг болгов.

11. “Алдарт эх” хоёрдугаар зэргийнодондтодорхойлох тухай

”Алдарт эх”-ийн хоёрдугаар зэргийн одонд Алдарт эх”-ийн хоёрдугаар зэргийн одонд 1-р багийн иргэн Загарын Зэсмаа, Лхавгын Отгон, 2-р багийн иргэн Дандарын Бундхорол, 6-р баг иргэн Настын Отгонтөгс нарын материалыг аймгийн ИТХуралд уламжлахыг сумын Засаг дарга Х.Дашдэлэг-д даалгав.

Хяналт шалгалтын талаар

ИТХурлын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Дотуур байрны барилгын ажлын явц гүйцэтгэлд, төсөвт албан байгуулагуудын гал тогоо бүхий газруудын хуванцар савны хэрэглээ, хүнсний аюулгүй байдал, орчны эрүүл ахуй болон “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” аяны хүрээний хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүн, Дотуур байрны хүүхдүүдийн хоолны хүртээмж, Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд тус тус хяналт тавин ажилласан.

Бусад зохион байгуулалтын талаар:

Сумын ИТХ-ын 2018 оны үйл ажиллагааны мэдээ, НӨУБайгууллагын мэдээг аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргэж ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарын хооронд үр дүнгийн гэрээ байгууллаа.

ИТХ-ын ажлын албанаас багийн ИНХурлын дарга нарт сургалт зохион байгуулж, төсвийн шууд захирагч, багийн ИНХурлын дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулав.

Төлөөлөгчид, Засаг дарга багийн Засаг дарга, Засаг даргын орлогч ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын нийт 25 албан тушаалтны 2018 оны ХАСХОМэдүүлгийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулан тайланг аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргэсэн.

ИТХ-ын ажлын албанд ирүүлсэн “Алдарт эх” хоёрдугаар зэргийн одонд орох 4 эхийн өргөдөл хүлээн авч ИТХТэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн аймгийн ИТХуралд уламжилсан.

ИТХ-ын төсвийг төлөвлөх, зарцуулах төсвийн зарчмыг мөрдлөг болгон хэрэгжүүлж, шилэн дансны тухай хуулийн дагуу сар, улирлын мэдээг шивж баталгаажуулсан.

ИТХурлын нарийн бичгийн дарга аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдаж ИТХурлын болон сонгуулийн холбогдолтой 1992-2018 оны архивын баримт бичигт техник боловсруулалт хийж баримт бичгүүдийг нэр төрлөөр нь байнга, түр хадгалах хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивын баримтыг цэгцэлж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: Ш.ЭЛБЭГЖАРГАЛ

